



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 11461

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Есөнбулаг сумын 3,4,7,8 дугаар байрны хашааны засвар хийх, Хасагт хайрхан гудамжны явган замын хавтан суурилуулах ажлын гүйцэтгэлийг хүлээн авч ашиглалтад оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Хаш-Эрдэнэ (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Алтанбагана (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн авто тээврийн хяналтын улсын байцаагч)

Б.Батбилэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын улсын байцаагч)

Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Ц.Бат-Орших (Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Ц.Эрдэмбилэг (Иргэдийн бүлгийн ахлагч, гүйцэтгэгч)

2.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, хөрөнгийн урсгал засвар, үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ашиглалтад хүлээн авахыг ажлын хэсэг (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2005 оны 08 сарын 04 өдөр

Дугаар АМ62


Бсөнбулаг

Д.Нармандахад "Аймгийн алдарт уяач"
цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн баяр наадамд удаа дараа амжилт гаргасан Халиун сумын уяач Доржийн Нармандахад "Аймгийн алдарт уяач" цол олгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР